



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
САЙД ЛУВСАННАМСРАЙН
ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2024.03.01 № 06

Хуулийн хэрэгжилтийг ханган
ажиллах болон хэрэгжилтийн
талаарх мэдээлэл ирүүлэх тухай

Монгол Улсын Их Хурал иргэн, аж ахуйн нэгжид учирдаг хүндрэл дарамтыг багасгаж, бизнес эрхлэгчдэд таатай орчин бүрдүүлэх, төрөөс олгодог зөвшөөрлийн тоог багасгаж, зөвшөөрөл олгох үе шатыг илүү хялбар, хүртээмжтэй болгох замаар бизнес эрхлэгч, аж ахуй нэгжүүдээ дэмжих, зөвшөөрөл олгохтой холбогдуулан үүсдэг авлига, хээл хахууль, төрийн албаны хүнд суртлыг арилгах зорилгоор Зөвшөөрлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны хаврын чуулганаар хэлэлцэн баталсан билээ.

Хууль хэрэгжиж эхэлснээр хуулиар хориглоогүй буюу хуульд зааснаас бусад үйл ажиллагааг иргэн, аж ахуйн нэгж чөлөөтэй эрхлэх боломж бүрдэж байгаа бөгөөд хуулиас гадуур журам гарган зөвшөөрлийн тоог нэмдэг байдлыг халж, зөвшөөрлийг цахимаар, олон нийтэд нээлттэй, ил тод олгох, байгалийн баялаг, төрийн нийтийн өмчийг хязгаартайгаар ашиглуулахдаа шударга өрсөлдөөний зарчмын дагуу явуулах зэрэг нэлээдгүй томоохон өөрчлөлтийг хуульчилсан.

Зөвшөөрийн тухай /Шинэчилсэн найруулга/ хууль 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж эхэлсэнтэй холбоотой Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 13 дугаар 13.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

Нэг.Зөвшөөрлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 17 дахь хэсэгт “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээ тогтоосон акт гаргахыг хориглоно” гэж заасантай холбогдуулан салбарын хуулиар захиргааны хэм хэмжээний акт гаргах эрх авсан зохицуулалтыг хүчингүйд болсонд тооцсон.

Захиргааны ерөнхий хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт “...хуульд заасан журмын дагуу хүчингүй болсон бол хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага энэ тухай албан бичгийг хүчингүй болгосон захиргааны хэм хэмжээний актын хуулбарын хамт хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ” гэж заасны дагуу салбар тус бүрээр хүчингүйд тооцсон захиргааны хэм хэмжээний актын мэдээлэл;

2024000016

Хүчингүйд тооцсонтой холбоотойгоор тухайн журмаар зохицуулж байсан харилцааг хуульчилсан эсэх.

Хоёр.Зөвшөөрлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “зөвшөөрлийн нэгдсэн бүртгэл хөтлөх, статистик мэдээг эрхлэн гаргах, лавлагаа өгөх, цахим хэлбэрээр зөвшөөрөл олгох зорилгоор зөвшөөрлийг кодолно” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт үндэсний кодыг эдийн засгийн үйл ажиллагааны ангилал, барааны ангиллын жагсаалтыг харгалзан эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоох асуудлыг хуульчилжээ. Зөвшөөрлийг кодлох ажлын хүрээнд хийгдэж буй ажлын явцын мэдээлэл;

Гурав.Зөвшөөрлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар 7 тусгай зөвшөөрлийг дуудлага худалдааны журмаар, 18 тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгох асуудлыг тусгажээ.

Дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын журмаар явагдсан зөвшөөрлүүдийн дэлгэрэнгүй танилцуулга /дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын журам, зөвшөөрөл тус бүрийн дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтаас олсон мөнгөн дүн, зарцуулалтын талаар мэдээлэл/;

Дөрөв.Зөвшөөрлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлээр зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сангийн асуудлыг зохицуулсан. Өөрөөр хэлбэл, зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явц болон зөвшөөрөл олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээллийг агуулсан зөвшөөрлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан ажиллахаар, уг мэдээллийн нэгдсэн санд эрх бүхий этгээд зөвшөөрөл хүссэн өргөдлийн явцын мэдээлэл, шийдвэрийг бүртгүүлж байх үүргийг хүлээсэн.

Уг зохицуулалтын дагуу төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нутгийн захиргааны байгууллага, төрийн зарим чиг үүргийг хуульд, эсхүл гэрээнд заасны дагуу шилжүүлэн авсан этгээдээс олгох зөвшөөрөлтэй холбогдох мэдээллийн сангийн бүрдүүлэлтийн талаар хэрэгжүүлж буй үйл ажиллагааны ажлын явцын талаар мэдээлэл;

Мөн зүйлийн 7-дахь хэсэгт эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зөвшөөрөл хүссэн болон сунгуулах өргөдлийг хүлээн авах, өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичгийг магадлан шалгах, шийдвэр гаргах үйл ажиллагааны явцыг зөвшөөрөл хүсэгч, зөвшөөрөл эзэмшигчид цахим хэлбэрээр, нээлттэй, ил тод байлгах асуудлыг мэдээлэл технологийн дэвшилтэт аргыг ашиглан хүртээмжтэй хэлбэрээр нийтэд мэдээлнэ гэж заасан. Энэхүү зохицуулалтын дагуу хийгдэж буй ажлын явц болон цаашид хийгдэх ажлын төлөвлөгөөний талаар мэдээлэл;

Тав.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1, 8.2 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш шинээр олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон шийдвэрийн талаарх мэдээлэл;

Зургаа.Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1-дэх хэсэгт “Эрх бүхий этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавих, энэ хуульд өөрчлөлт оруулах үндэслэл,

шаардлагын талаар санал, дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Ерөнхий сайдын дэргэд ажиллана” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 11 гишүүнээс бүрдэх бөгөөд Зөвлөлийг Ерөнхий сайд тэргүүлнэ” гэж, 4 дэх хэсэгт “Зөвлөлийн гишүүдийг томилх, чөлөөлөх, тэдгээрийн ажиллах журмыг Засгийн газар батална” гэж тус тус заажээ. Энэхүү Зөвлөлийн ажиллах журам, Зөвлөлийн бүрэлдэхүүний нэрс болон тэдгээрийг хэрхэн сонгон шалгаруулсан, мөн Зөвлөлийн энэ жилийн ажиллах төлөвлөгөөний талаар мэдээлэл;

Долоо.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт “Хууль тогтоомжийг боловсронгуй болгох арга хэмжээ авч, эрх зүйн мэдээлэл, сургалт, хууль тогтоомж тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулна” гэж заажээ.

Зөвшөөрлийн тухай хуулийг сурталчлан таниулах, түгээх, мэдээ, мэдээллээр хангах ажлын хүрээнд хийгдсэн ажиллын талаар мэдээлэл;

Найм.Зөвшөөрлийн тухай хуульд зөвшөөрлийг шинээр бий болгох тохиолдолд хууль санаачлагч Нийтийн сонсголын тухай хуульд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн сонсгол явуулах, мөн Зөвлөл хуульд өөрчлөлт оруулах асуудлаар санал, дүгнэлт гаргаж, Засгийн газарт танилцуулснаар тухайн зөвшөөрлийг нэмэх эсэх асуудлыг шийдвэрлэхээр хуульчилсан.

Уг заалтын дагуу Зөвшөөрлийн тухай хуульд шинээр нэмсэн зөвшөөрлийн талаар мэдээлэл.

Энэхүү асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасан хугацааны дагуу бичгээр ирүүлэх бөгөөд, мөн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулах болно.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН

Х.ГАНХУЯГ



2024000016